

**Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, клиник, болон төрөлжсөн мэргэжлийн
эмнэлэг, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, нэгдсэн
эмнэлгийн дарга, захирал танаа**

Албан тоот хүргүүлэх тухай

1. Халдварт Өвчинтэй Тэмцэх Монголын Үндэсний Холбоо нь 2013 онд дараах мэргэжлээр эмнэлгийн ахлах, тэргүүлэх, зөвлөх зэргийн шалгадтыг авах гэж байна.
Үүнд : - тархвар судлаач бага эмч
- тархвар судлаач их эмч
- халдвартын их эмч
2. Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвийн 2013 оны 1 дүгээр сарын 21-ны өдрийн 69 тоот албан тоотод дурдсан мэргэжлийн зэрэг олгох нийтлэг шалгуур, мэргэжлийн зэрэг горилох мэргэжилтний бүрдүүлэх материал болон тус холбооноос гаргасан тусгай шалгуур үзүүлэлтийг хангасан мэргэжлийн зэрэг горилогчийн материалыг 2013 оны 2 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү. Хаяг : ХӨСҮТ-ийн 1а корпус 4 давхарт 407 тоот өрөө, холбооны гүйцэтгэх захирал Ч.Мөнхцэцэг (утас 99136244)-т хүлээлгэн өгнө үү.
3. Ахлах, тэргүүлэх, зөвлөх зэрэг горилогчдоос онолын шалгалт авч тэнцсэн тохиолдолд дадлага шалгалт авах болно.
4. Мэргэжлийн зэрэг горилогчдын бүрдүүлсэн материал дутуу, хугацаа хоцорсон тохиолдолд хүлээн авахгүй болохыг мэдэгдье.
5. Горилогчдод олгох ахлах, тэргүүлэх, зөвлөх зэргийн тусгай шалгуур үзүүлэлтийг хавсаргав.

ТЭРГҮҮН

П.НЯМДАВАА

Мэргэжлийн зэрэг олгох тусгай шалгуур

Дараах шаардлага хангасан эмнэлгийн мэргэжилтэнд ахлах зэрэг олгох эрхтэй.

- Мэргэжлээрээ бие даан мэргэжлийн санал, дүгнэлт гаргах, сургалт явуулах түвшинд хүрсэн байх. /гаргасан санал, дүгнэлт, хийсэн сургалт, түүнийг баталгаажуулах баримт /
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний ёс зүйн зөрчил, мэргэжлийн алдаа дутагдал гаргаагүй, байгууллагын дэн журам зөрчөөгүйг байгууллагын удирдлага тодорхойлж, хамт олон дэмжсэн байх / Энэ талаарх байгууллагын удирдлагын тодорхойлолт, хамт олны протокол/
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд идэвхтэй оролцож, бүтээл, ном, гарын авлага, зөвлөмж, санамж боловсруулсан байх. /эх хувь/
- Зэрэг горилох мэргэжлийн дагуу мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан байх / мэргэжлийн үнэмлэх эх хувь/
- Тухайн жилд сургалт, семинарт оролцсон байдал, сертификат авсан эсэх

Дараах шаардлага хангасан эмнэлгийн мэргэжилтэнд тэргүүлэх зэрэг олгох эрхтэй.

- Эмнэлгийн тусламж үйлчилгээний ёс зүйн зөрчил, мэргэжлийн алдаа дутагдал гаргаагүй, байгууллагын дэн журам зөрчөөгүйг байгууллагын удирдлага тодорхойлж, хамт олон дэмжсэн байх /Энэ талаарх байгууллагын удирдлагын тодорхойлолт, хамт олны протокол/.
- Хоёроос доошгүй мэргэшигчийг дагалдуулан сургах мэргэжлийг нь дээшлүүлсэн байх. / Мэргэшигчийн овог нэр, ямар мэргэжлээр, ямар тушаалаар баталгаажсан /
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд идэвхтэй оролцсон байдал, бүтээл, ном гарын авлага, зөвлөмж, санамж боловсруулсан байх. / эх хувь, жагсаат гаргах/
- Шинэ арга технологи, дадлага эзэмшиж үр дүнд хүрсэн байх./зохиогчийн эрхийн гэрчилгээ байж болно/
- Мэргэжлээрээ бие даан мэргэжлийн санал, дүгнэлт, тушаал, журам, заавар хөтөлбөр, стратеги боловсруулсан байдал, сургалт зохион байгуулсан байдал

Дараах шаардлага хангасан эмнэлгийн мэргэжилтэнд зөвлөх зэрэг олгох эрхтэй.

- Эмнэлгийн тусламж үйлчилгээний ёс зүйн зөрчил, мэргэжлийн алдаа дутагдал гаргаагүй, байгууллагын дэн журам зөрчөөгүйг байгууллагын удирдлага тодорхойлж, хамт олон дэмжсэн байх /Энэ талаарх байгууллагын удирдлагын тодорхойлолт, хамт олны протокол/.
- Таваас доошгүй мэргэшигчийг дагалдуулан сургах мэргэжлийг нь дээшлүүлсэн байх. / Мэргэшигчийн овог нэр, ямар мэргэжлээр, ямар тушаалаар баталгаажсан, хотод бол 5 хүн, хөдөө бол 3 хүн /
- Шинэ арга технологи, дадлага эзэмшиж үр дүнд хүрсэн байх./зохиогчийн эрхийн гэрчилгээ байх/
- Мэргэжлээрээ бие даан мэргэжлийн дүгнэлт, бодлогын бичиг баримт, хууль, тушаал, журам, заавар хөтөлбөр, стратеги боловсруулсан байдал, сургалт зохион байгуулж үр дүнг тооцсон байдал
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийсэн, бүтээл, ном гарын авлага, зөвлөмж боловсруулсан байх./ эх хувь, жагсаалт/